

Засаг даргын Тамгын газрын даргын  
2020 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн  
0/154 дугаар тушаалын 45 дугаар хавсралт



## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Хууль тогтоомжийн нэр огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо

Байгууллагын нэр:

Дүүргийн Засаг даргын Тамгын газар

Нэгжийн нэр:

Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс

Албан тушаалын нэр:

Хоол үйлдвэрлэл, зочид буудал хариуцсан мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-4

Ажлын цаг

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж-16

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хоол үйлдвэрлэл, аялал жуулчлалын үйлчилгээний салбарын бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг бүртгэх, мэргэшил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Хэлтсийн даргын өмнө хариуцна.



## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан  
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Хууль тогтоомжийн нэр огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар

Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Хоол үйлдвэрлэл, зочид буудал хариуцсан мэргэжилтэн

Дэс түшмэл, ТЗ-4

Ажлын цаг

Ажлын байрны албан ёсны байршил

Ажлын өдөр 8 цаг

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж-16

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл

Хэвийн

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хоол үйлдвэрлэл, аялал жуулчлалын үйлчилгээний салбарын бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг бүртгэх, мэргэшил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Хэлтсийн даргын өмнө хариуцна.

<u>Албан тушаалын зорилт:</u>			
<p>1.Хоол үйлдвэрлэл, аялал жуулчлалын үйлчилгээний салбарын бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, тайлагнах.</p> <p>2.Үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийг бүртгэх, мэдээллийн сан үүсгэх, зөвшөөрөл олгох, мэргэшил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих, тайлагнах.</p> <p>3.Үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулах, шалгалтын мөрөөр арга хэмжээ авах.</p> <p>4.Байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.</p>			
Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр <i>Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах-Х Шийдвэрлэх -Ш</i>
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Ерөнхий менежерээс хэлтсийн даргатай байгуулах бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд хүнсний хангамж, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ болон аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхтэй холбогдолтой зорилтыг тусгах, хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	2.Нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жил бүрийн эдийн засаг, нийгмийн зорилтод хоол үйлдвэрлэл, үйлчилгээ болон аялал жуулчлалын чиглэлээр тусгагдах хөгжлийн стратегийн зорилтыг тодорхойлж боловсруулахад шаардлагатай бодлогын зөвлөгөө, мэдээллээр хангах;	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	3.“Нийслэлийн соёлыг тодорхойлогч хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллага”-ын тоог нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх.	Аюулгүй, чанартай хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын тоо нэмэгдсэн байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ болон аялал жуулчлалын салбарын мэдээллийн баазыг бий болгоход шаардлагатай судалгааг цаг хугацаанд гаргаж холбогдох байгууллагад хүргүүлж ажиллах;	Судалгаа дүгнэлтэд тулгуурласан мэдээллийн баазтай болно.	Г



	2.Хоол, хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлын холбогдолтой мэдээллийг бодит судалгаанд түшиглэн хэрэглэгчдэд хүргэх ажлыг зохион байгуулах;	Иргэд хоол, хүнсний аюулгүй байдлын талаарх мэдээллээр хангагдсан байна.	Г
	3.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ болон аялал жуулчлалын салбарт ажиллаж буй үйлчилгээний ажилтнуудыг мэргэжлийн ур чадварын шалгалтад хамруулж, улсаас баталгаажуулах ажлыг зохион байгуулах;	Үйлчилгээний ажилтнуудын мэдлэг, ур чадвар дээшилсэн байна.	Г
	4.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг олон улсын уралдаан, сургалт, семинар, үзэсгэлэнд зохион байгуулалттайгаар оролцуулах замаар мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	Үйлчилгээний ажилтнуудын мэдлэг, ур чадвар дээшилсэн байна.	Г
	5.Сургуулийн хүүхдийн "үдийн цай", "халуун хоол" хөтөлбөрийг хүүхдийн эрүүл мэндийг хамгаалж, улмаар хөгжүүлэх чиглэлээр шинжлэх ухааны үндэслэлтэй эрүүл хоолны хөтөлбөр болгон хэрэгжүүлэх, дүүргийн сургуулиудыг хоолоор хангах төвлөрсөн гал тогоог тусгайлан байгуулах асуудлыг судлан санал боловсруулж, холбогдох газруудад хүргүүлэн хамтран ажиллах;	Сургуулийн хүүхдүүд эрүүл хоол хүнсээр хангагдсан байна.	Г
	6.Онцгой нөхцөл байдлын үед хамтран ажиллах байгууллага иргэдтэй гэрээ байгуулах замаар хоол, хүнсээр хангах нөхцөлийг бүрдүүлэх.	Онцгой байдлын үед хоол хүнсээр хангагдсан байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Дүүргийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ болон аялал жуулчлалын салбарт ажиллаж буй аж ахуйн нэгжийн мэргэжилтнүүдэд ажлын чиглэл өгч, хэрэгжилтийн удирдлагаар хангах, арга зүйн зөвлөгөө өгөх, ажлын үр дүнг үнэлэх;	Салбарын мэргэжилтнүүдийн мэдлэг дээшилсэн байна.	Г
	2.Дүүргийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ болон аялал жуулчлалын салбарт ажиллаж буй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулах, шалгалтын мөрөөр арга хэмжээ авах;	Хяналт шалгалт хийгдсэн байна.	Г



	3.Согтууруулах ундаагаар үйлчилдэг ресторан, баар, кафенуудад аттестатчилал явуулж, холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх.	Хэрэгжилт хангагдсан байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэх, хууль тогтоомж болон дотоод ажил үүргийн хуваарийн дагуу хариуцуулж өгсөн ажлыг хэрэгжүүлж ажиллах;	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдсан байна.	Г
	2.Иргэд, байгууллагаас ирсэн өргөдөл гомдол, санал хүсэлт, мэдээллийг судлан шалгаж, хуулийн дагуу шийдвэрлэн, хариуг өгөх;	Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэсэн байна.	Г
	3.Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, холбогдох дүрэм, журмын хүрээнд албан хэрэг хөтлөх, Архивын тухай хууль, зааврын дагуу хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад тусгагдсан холбогдох материалыг архивын хадгаламжийн нэгж болгон тогтоосон хугацаанд архивд шилжүүлэх.	Холбогдох материалыг архивд хүлээлгэн өгсөн байна.	Г

### III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй.	
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> <li>- Хүнс үйлдвэрлэлт /0721/;</li> <li>- зочид буудал, ресторан, нийтийн хоол /1013/;</li> <li>- аялал жуулчлалын менежмент /041304/;</li> <li>- аялал, жуулчлал, чөлөөт цаг /1015/.</li> </ul>	
Мэргэшил	Төрийн албаны богино, дунд хугацааны сургалтад хамрагдсан байх.	
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулж, дүгнэх;</li> <li>- мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх;</li> <li>- судалгааны арга зүйн мэдлэгтэй байх;</li> <li>- тоон судалгаанд үндэслэн харьцуулалт, шинжилгээ хийх;</li> <li>- тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийж, нөхцөл байдал, хувилбарыг тодорхойлох чадвартай байх;</li> <li>- бусад.</li> </ul>



	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>- үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх;</li> <li>- тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хувилбарыг боловсруулж түүний эерэг, сөрөг үр дагаврыг тодорхойлох;</li> <li>- хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэр гаргах;</li> <li>- асуудлыг хууль журам, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх;</li> <li>- гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах;</li> <li>- аливаа асуудлыг шийдвэрлэхдээ хамт олны саналыг харгалзан үздэг байх;</li> <li>- бусад.</li> </ul>
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> <li>- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах, үлгэрлэн манлайлдаг байх;</li> <li>- бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох;</li> <li>- маргаантай асуудалд хүлээцтэй ханддаг байх;</li> <li>- багийн амжилтыг дэмжиж бусдад таниулах;</li> <li>- бүтээлч санаачилгатай ажиллах;</li> <li>- хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын хувьд бусдыг үлгэрлэн манлайлах;</li> <li>- бусад.</li> </ul>
	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлний зохих мэдлэгтэй байх;</li> <li>- компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт техник, технологи ашиглах;</li> <li>- багаар ажиллах, амжилтыг дэмжиж бусдад таниулах;</li> <li>- байгууллагын болон хувь хүний нууцыг хадгалах;</li> <li>- төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх.</li> <li>- бусад.</li> </ul>

#### IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга.

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Байхгүй.

Бусад харилцах субъект:

- яам, агентлагийн холбогдох албан тушаалтан;
- нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын холбогдох албан тушаалтан;
- төрийн болон төрийн бус байгууллага;
- иргэн, хуулийн этгээд.



**V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ**

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

Байгууллагын нэр:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

...../Б.МӨНГӨНСҮХ/

Шийдвэрийн огноо: **20 06 10**

2020 оны **12** дугаар сарын **28**-ны өдөр

Дугаар: **219**

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Шийдвэрийн огноо: **2020/12/28**

Дугаар: **0/454**  
(тамга/тэмдэг)

ДАРГА...../П.БАЯНБААТАР/

2020 оны **12** дугаар сарын **28**-ны өдөр

